



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/2/НА-СТА-ОНТС

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	-
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	151,671,831.15	150,176,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	219,831.15	-
120	Нийтлэг татварын бус орлого	219,831.15	-
120002	Хүүгийн орлого	219,831.15	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,452,000.00	150,176,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,452,000.00	150,176,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,452,000.00	150,176,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	151,671,831.15	150,176,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,671,831.15	150,176,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,999,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,999,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,999,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,671,831.15	145,176,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,772,500.00	138,176,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	150,772,500.00	138,176,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	899,331.15	7,000,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	899,331.15	7,000,300.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	151,671,831.15	150,176,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	219,831.15	-
120	Нийтлэг татварын бус орлого	219,831.15	-
120002	Хүүгийн орлого	219,831.15	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,452,000.00	150,176,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,452,000.00	150,176,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,452,000.00	150,176,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	151,671,831.15	150,176,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,671,831.15	150,176,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,999,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,999,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,999,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,671,831.15	145,176,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,772,500.00	138,176,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	150,772,500.00	138,176,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	899,331.15	7,000,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	899,331.15	7,000,300.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00		0.00	0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00		0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D09	2021 оны 09-р сарын 30-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Багтагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150,176,000.00	143,175,700.00	7,000,300.00	95.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,176,000.00	143,175,700.00	7,000,300.00	95.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.00	4,999,700.00	300.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,999,700.00	300.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,999,700.00	300.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,176,000.00	138,176,000.00	7,000,000.00	95.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,176,000.00	138,176,000.00	7,000,000.00	95.2
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	145,176,000.00	138,176,000.00	7,000,000.00	95.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150,176,000.00	143,175,700.00	7,000,300.00	95.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	150,176,000.00	143,175,700.00	7,000,300.00	95.3
132001	Орон нутгийн төсвөөс	150,176,000.00	143,175,700.00	7,000,300.00	95.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд сангийн хөрөнгийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Д.Амарсанаа, 2 дугаар гарын үсгийг 2021.01.01-2021.08.31 хүртэл хугацаанд халамжийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Долгорсүрэн, 2021.09.01-2021.12.31-ийг хүртэл Захиргаа хяналтын хэлтсийн дарга Д.Одонтунгалаг нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн Халамжийн сангийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн сангийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг бодитой, үнэн зөв боловсруулах, холбогдох газруудад хүргүүлэн батлуулах.
- Батлагдсан төсвийн зарцуулалтыг улирал, хагас бүтэн жилээр иргэдэд болон хэлтсийн удирдлага хамт олонд нээлттэй тайлагнаж ажиллах
- Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах чиглэлээр санал санаачилга гарган, анхан шатанд ажиллаж байгаа ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах
- Нийгмийн халамжийн сангийн санхүүжилтийг цаг хугацаанд нь авах, бодитой, үнэн зөв хуваарилах, гэрээт банк уруу шилжүүлэх ажлыг чанартай зохион байгуулах
- Хуульд заасан тусламж хөнгөлөлтийн мөнгийг нэхэмжлэлийн дагуу холбогдох байгууллагад шилжүүлэх.
- Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлын баримт материалыг журмын дагуу бүрдүүлэн хүлээн авч, санхүүжилтийг журмын дагуу олгох. Амьжиргаа дэмжих зөвлөлийн ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмж чиглэл өгөх, сургалт зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 151,452.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,271.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,590.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 2,552.6 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн Халамжийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлангаарх нийт зардлын дүн өмнөх оноос 1,276.6 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Зардлын дансны тодруулга

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,452.00	150,176.00	1,276.00
Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	151,452.00	150,176.00	1,276.00
Бараа, үйлчилгээний орлого	219.83	-	219.83
Орон нутгийн төсвийн хүүгийн орлого	219.83	-	219.83

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	151,671.83	150,176.00	1,495.83
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	150,772.50	138,176.00	7,596.80
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	85,200.00	69,600.00	15,600.00
Бараа, үйлчилгээний зардал	-	4,999.70	(4,999.70)
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	65,572.50	68,576.00	(3,003.50)
Бараа, үйлчилгээний зардал	-	4,999.70	(4,999.70)
Төсөвт төвлөрүүлэх	899.33	7,000.30	(6,100.97)
Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	899.33	7,000.30	(6,100.97)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	151,671.83	150,176.00	1,495.83

Эх сурвалж: Баянхонгор аймгийн орон нутгийн төсвийн халамжийн сангийн тайлан

Өмнөх онд сангийн арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл 1,326.6 мянган төгрөгийг тайлант онд улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 197,200.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 197,200.0 мянган төгрөгөөр буюу онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийн зардалд 103,200.0 мянга, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 94,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 47,024.0 мянган төгрөгөөр бууруулж 150,176.0 мянган төгрөгөөр буюу онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийн зардалд 103,200.0 мянга, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 46,976.0 мянган төгрөгөөр анх баталсан ба аймгийн Засаг даргын 2021 оны “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/289 дүгээр захирамжаар зардлын ангилалд зохицуулалт хийж онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийн зардалд 76,600.0 мянга, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 68,576.0 мянга бараа, үйлчилгээний зардалд 5,000.0 мянган төгрөг баталж өгсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээний 150,176.0 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс авах 150,176.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 68,576.0 мянга, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийн зардалд 69,600.0 мянга, сангийн хяналт, үйл ажиллагааны зардалд 4,999.7 мянган төгрөг зарцуулж 7,000.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус сангаас Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу тайлант онд 487 иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ олгосон байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийгмийн халамжийн бодлогын хүрээнд нийт 2 зорилго, 3 зорилт, 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 98.0 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 150,176.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1,276.0 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Энэ нь тайлант оны онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийн зардал өмнөх оноос 10,600.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 253,815.0 мянган төгрөгийн 11 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нийгмийн халамжийн

зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажиллах 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____ оОо _____